



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 6/41

Хэрлэн сум

Б.Цэцэгмаагийн хөдөлмөрийн
гэрээг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, 43 дугаар зүйлийн 43.1.1, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтнээр ажиллаж байсан Балдангомбын Цэцэгмааг 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Б.Цэцэгмаагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Цэцэгсүрэн

Аймгийн Төсвийн ерөнхийлөн
захирагчийн Төсвийн ерөнхий нягтлан
бодогч


Д.Энхтуяа

Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Зарлагын мэргэжилтэн Г.Ариунхүүгээр бүртгэлийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.

3. Б.Цэцэгмаагийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг Комиссын бүрэлдэхүүн (С.Нямдаваа)-д, ээлжийн амралтын болон холбогдох тооцоог хийж дуусгахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР